

I. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Өндөр овоо”-ийн хайлуур жоншны ордын нийт нөөцийг 42,346.08 тн хүдэр, үүнээс бодитой (В) нөөцийг 6528.63 тн эрдэс агуулсан 15,147.68 тн хүдэр, боломжтой (С) нөөцийг 11,562.41 тн эрдэс агуулсан 27,198.4 тн хүдэр тус тус тогтоож Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн Дугаар ХХ-17-06 тоот дүгнэлт, Ашигт малтмалын газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн Дугаар н/09 тоот тушаалаар Монгол улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

Төсөл хэрэгжүүлэгч: “ХДТ” ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011662124

Регистрийн дугаар: 6165524

Хаяг: Улаанбаатар, Хан-уул, 11-р хороо, 7 хэсэг, оргил, стар 58 байр, 85 тоот

Утас: 88053300

“Өндөр овоо – Толгод” хайлуур жоншны орд нь Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 330 км-т, Хэнтий аймгаас 144 км, Дархан сумаас зүүн урагш 38 км, Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрээс хойш 6 км, Дорноговь аймгийн Даланжаргалан сумаас зүүн хойш 52 км болон Бор-Өндөрийн төмөр замын өртөөнөөс хойш 7 км зайд тус тус байрлана.

ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ НУТГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Уул зүйн байрлал: Бага хэрчигдэлтэй намхан уулс, толгод, гүвээрхэг гадаргуу бүхий тачир ургамлын бүрхэвчтэй ой мод, гол горхигүй, хуурай эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд оршдог. Уул толгод нь тэгшивтэр бөмбөгөр оройтой, налуу хажуутай, гуу жалгандаа үерийн усаар идэгдсэн, эгц эрэгрэг гуу, хуурай сайрнуудтай, толгод хоорондын битүү хотгоруудад хур бороотой үед түр зуурын жижиг нуур цөөрөм үүсдэг. Талбайн хэсэгт орших хамгийн өндөр цэг нь далайн түвшингээс дээш 1500 м-т өргөгдсөн ба хамгийн нам дор цэг нь 1200 м-ийн уулс хоорондын жижиг хөндий болно. Толгодын харьцангуй өндөр 40–70 м-т хэлбэлзэнэ. Судалгааны талбайд ой мод, намаг шавар байхгүй.

Усан сүлжээ: Судалгааны талбайд ой мод, намаг шавар байхгүй. Зуны улирлын сүүлч, намрын ширүүн аадар борооны дараа хуурай сайруудаар хэмжээс чулуу зөөвөрлөсөн түр зуурын үерийн ус урсдаг. Гадаргуугийн нам дор хэсгүүдэд оршдог жижиг нуур тойрмууд нь агаарын хур тунадасаар тэжээгдэнэ.

Уур амьсгал: Судалгааны талбай нь жилийн дөрвөн улирал ээлжлэн солигддог эх газрын эрс тэс уур амьсгалтай. Улирлын температурын зөрүү их. Өвөл нь -37.5 хэм хүртэл хүйтэрнэ. Зун хамгийн их халж +34.9-өөс +40 хэм хүрнэ. Жилд унах хур тунадасны хэмжээ дунджаар 277 мм бөгөөд үүний 70 гаруй хувь нь зуны улиралд бууна. Жил бүрийн 10-р сарын сүүл үеэс цас орж хүйтний улирал эхэлдэг. Салхины хурд 6–8 м/сек-ээс 18 м/сек хүрнэ. Заримдаа түүнээс ч хүчтэй шороон шуурга шуурна. Цасан бүрхүүл ихэвчлэн жил бүрийн 11-р сарын 2 дугаар хагаст эхлэн тогтож, дараа жилийн 3-р сарын сүүлч, 4-р сарын эхээр бүрэн хайлдаг. Жилд дунджаар 79–95 орчим хоногийн туршид харьцангуй бага зузаантай цасан бүрхүүл тогтдог боловч уул толгодын хойд ташлаг болон хөндий хотгорын ай савын хэсэгт цасан бүрхүүлийн хамгийн их зузаан 18–20 см хүрдэг.

Амьтны аймаг: Энэ нутагт тал хээрийн жижиг мэрэгч болон цагаан зээр, аргаль, янгир болон жигүүртэн амьтад амьдардаг. Агнуурын ан амьтдаас чоно, үнэг, хярс, бор туулай, дорго, өмхий хүрэн, мануул, цагаан зээр, тарвага зэрэг ан амьтан элбэг тааралдах ба сүүлийн жилүүдэд байгалийн хувьсан өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас тарвага, цагаан зээр зэрэг агнуурын ан амьтад эрс ховордсон байна.

Засаг захиргаа, хүн ам: Хэнтий аймаг нь 80.3 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй 17 сум, 83 багтай. Хамгийн том газар нутагтай сум болох Өмнөдэлгэр сум нь 10.9 мянган км² нутаг дэвсгэртэй бол хамгийн жижиг газар нутагтай нь Мөрөн сум буюу 2.2 мянган км² нутаг дэвсгэртэй юм. Хойд талаараа ОХУ-тай хил залгана. Улс дотор Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр, Төв, Сэлэнгэ аймгуудтай, нийслэлийн Багануур дүүрэгтэй хиллэдэг.

Бор-Өндөр сум нь Монгол улсын зүүн хэсэгт, Хэнтий аймгийн баруун өмнөд хэсэгт, нийслэл Улаанбаатар хотоос 300 км, аймгийн төв Чингис хотоос 145 км, Дархан сумаас баруун урагш 45км зайд оршино. Хэнтий аймгийн Бор-Өндөр сум нь 1981 онд Хэрлэн хороо гэж байгуулагдаж, газар нутгийн харьяалал нь хуучнаар Хэнтий аймгийн Дархан сумын 5-р баг байсан. УИХ-ын 2012 оны 02 сарын 09 ний өдрийн 15-р тогтоолоор Бор-Өндөр сум болон өөрчлөгдөж, 2012 оны 12 дугаар сараас эхлэн сумын бүтэц зохион байгуултад орсон. Өмнөд хэсгээрээ Дорноговь аймгийн Айраг сумтай, бусад хэсгээрээ Хэнтий аймгийн Дархан сумтай хиллэдэг.

Дэд бүтэц: Тусгай зөвшөөрлийн талбай нь Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутагт байрлах ба сумын төвөөс баруун тийш 4 км зайд оршдог. Орд орчмын ойрхон төв суурин газар нь Бор-Өндөр суурин байдаг. Энд сум дундын шүүх, эмнэлэг, сургууль, шуудан холбоо, дэлгүүр бусад үйлчилгээний газруудтай. Мөн Бор-Өндөрийн уурхай нь Чойртой 110 кВт-ийн шугамаар, мөн 35 кВт-ийн шугамаар Бор-Өндөр сумтай тус тус холбогдсон. 110 кВт-ийн шугам нь “Бор-Өндөрийн хүдрийн дүүргийн Өндөр-Овоо хайлуур жоншны ордын 30-р хүдрийн биет” ордын баруун урд талаар 1000 м зайнд

өнгөрдөг. Харилцаа холбооны хувьд Mobicom, Unitel, Skytel, G.mobile зэрэг бүх үүрэн холбооны операторуудын сүлжээ маш сайн хөгжсөн байдаг.

Төмөр замын өртөөний хувьд Хар-Айрагийн өртөөнөөс хойд зүгт 50 км-т Бор-Өндөр өртөө орших ба энэ өртөөнөөс баруун хойшоо 4 км-т “Бор-Өндөрийн хүдрийн дүүргийн Өндөр-Овоо хайлуур жоншны ордын 30-р хүдрийн биет” орд байрлана. Жилийн аль ч улиралд ердийн шороон замаар саадгүй зорчих боломжтой. Улаанбаатар хотоос зүүн урагш Замын-Үүдтэй холбосон асфальтан засмал замаар Даланжаргалан хүртэл 300 км, Даланжаргалангаас зүүн хойш 52 км явж “Толгод” талбайд хүрнэ. Улаанбаатар-Чойр, Замын-Үүдийн мянганы хатуу хучиттай зам нь нутгийн баруун талаар 100 км зайтай өнгөрдөг.

Эдийн засгийн байдал: Хүн ам харьцангуй ихтэй, гол төлөв уул уурхайн үйлдвэрүүд болон төмөр замын өртөөнүүдэд ажил эрхэлдэг. Тус бүс нутаг нь өгдөр хүчдэлд холбогдсон, төмөр замд холбогдсон, уулын баяжуулах үйлдвэртэй, дэд бүтэц сайн хөгжсөн ба эдийн засгийн хувьд таатай нөхцөл бүрдсэн нутаг юм.

Газар зүй: “Толгол” талбай нь газар зүйн байрлалын хувьд Хэнтий нурууны зүүн урд хэсэг, говийн мужийн хойд хилтэй хиллэх зааг орчмын говь хээрийн бүсийн завсрын шинж төрхийг бүрдүүлсэн намхавтар уул толгодын бүсэд байрлах ба тэдгээрийг жижиг хөндийнүүд, ухаа гүвээт талууд хүрээлж оршино. Мөн уг талбай нь Бор-Өндрийн хүдрийн зангилааны бүсэд байрлах бөгөөд тус зангилаа бүс нь Дорноговь, Хэнтий аймгуудын нутаг дэвсгэрт орших ба Хэрлэн голын тохойрсон хэсгээс баруун урагш байрлах газар нутгийг хамардаг.

Ургамал зүй: Тус сумын нутаг ботаник газар зүйн мужлалаар дээгүүр, Монгол хээрийн тойргийн Нялгын дүүрэгт хамаарна. Уулын хээрт: Цахилдаг, алаг өвөст, хиаг-хялганат, бужмаг, хонгорзул, улалж, бут бударгана, харгана, халгай, буурцагт өвсний төрөл зонхилно. Тал хээрт: Үетэн хялганат, хазаар өвс, хиаг-хялганат, шарилж, лууль, дэрс болон амт чанар, шимт сайтай үетэн, буурцагт, алаг өвсний төрлийн ургамар зонхилно. Мөн гол, булаг, нуур тойрмын хөвөөгөөр хйаг, хазаар өвс, салхин ерхөг, дэрс, харгана, адамсын агь, хэрс зэрэг ургамал ургадаг ба сумын урд говирхог талаараа таана, мангир, хөмүүл, ерхөг, үетэн хялганат, алаг өвс, жижиг бутан үетэн, ботуульт ургамал зонхилон ургадаг байна. Сумын нийт бэлчээрийн 4.5 хувь нь цэвэр бэлчээр 59 хувь нь сөөгт бэлчээр, 22 хувь нь чулуурхаг бэлчээр, 14.5 хувь нь довонтой бэлчээр байна. Эмийн ургамалаас: Юлдэн тарваган шийр, өргөст сарнай, нохойн хошуу, говийн ганга, таван салаа, царван, хөх дэгд, шар дэгд, цөс өвс, арц, банздоо, бошго, сөд, соргол зэрэг олон зүйлийн эмийн ургамал ургадаг.

II. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Байгаль орчинд: Төслийн үйл ажиллагаанаас 139 сөрөг нөлөөллийг байгаль орчны бүрэлдхүүн хэсэг тус бүрд үзүүлэхээр байна. Үүний 3 буюу 7.1% нь “бага”, 19 буюу 45.2% нь “дунд”, 18 буюу 42.8% нь “их”, 2 буюу 4.8% нь “маш их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамаарагдаж байна. Эндээс үзхэд төслийн зүгээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хэмжээ дундаас их хэмжээнд байхаар байна. Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийн хэмжээ агаарын чанарт 19%, газрын гадарга, хэвлийд 19%, хөрсөн бүрхэвчид 17%, газрын доорхи усанд 15%, ургамлан нөмрөгт 15% амьтны аймагт 15% гэсэн үзүүлэлт гарч байгаа ба газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл илүү байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

- Тоосжилт үүсгэх гол эх үүсвэрүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төслийн эхний үе шатанд төлөвлөн, цаашид энэхүү сөрөг нөлөөллийг бууруулсан арга, туршлага, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, дэвшилтэт техник, технологийг хэвтрүүлж ашиглах
- Хөрс хуулсан талбай болон эвдрэлд орсон газрын боломжтой хэсгийг нь тухай бүрт нь үржил шимт хөрсөөр бүрхэж ургамалжуулах
- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг стандартын дагуу хийх
- Хөрсний овоолгыг салхинд хийсч, тоос шороо дэгдэхээс урьдчилан сэргийлж, овоолго түүний ойр орчимд салхины хурд бууруулах хаалт хийх
- Овоолгыг цаг тухайд нь тэгшилж, нягтруулах, хэлбэржүүлэх, чийглэж гадаргууг дагтаршуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.
- Төслийн талбайн дотоод тээвэрлэлтийг аль болох олон салаа зам гаргахгүйгээр тээвэрлэх
- Орчны агаарт ялгуулах хорт утаа хийг багасгахын тулд техникийн тогтмол засвар, үйлчилгээг хийж байх.
- Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх
- Тээвэрлэлтийг явуулахдаа замын тогтсон маршрут гаргах, мөрдүүлэх, мөн хүнд даацын тээврийн хэрэгслийн зөөвөрт явах үеийн хурдыг тогтоох (хурдтай явах тусам тоосжилт нэмэгдэн техник эвдрэл гарна), хяналт тавих
- Хатуу хаягдлыг ахуйн гарал үүслээр нь ялган ангилж хадгалах, төвлөрсөн цэгүүдэд зайлуулах хэрэгтэй.
- Түр амьдрах байр болон засварын хэсэгт бий болох ахуйн болон шатхуун, тослох материалын хаягдал үерийн усаар зөөгдөж хөрс бохирдохоос сэргийлж зориулалтын саванд цуглуулах, төв суурин газарт зөөвөрлөж зайлуулах шаардлагатай.

Усны чанарт тогтмол хяналт шинжилгээ хийж байх

Хүний эрүүл мэндэд: Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилт, тэсэлгээ, дуу чимээ, техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний аюулгүй байдал зэрэг уурхайн ажилчид, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нийт 31 нөлөөллийг тооцов. Тэдгээр нөлөөллүүдийн 14 буюу 45% нь бага, 17 буюу 55% нь дунд зэргийн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамрагдаж байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга

Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА тухай хууль, бусад холбогдолтой дүрэм журам, стандартын шаардлагуудыг мөрдөх, дотоодын хяналтын журам аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг нийт ажилтнуудад мөрдүүлэх, хяналт тавих шаардлагатай.

Нийгэм эдийн засагт: Төсөл хэрэгжих суманд ажлын байр нэмэгдэх, орон нутгийн худалдан авалт сайжрах, төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмийн албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлөрийг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу тооцоолон татвар хэлбэрээр улс болон орон нутгийн төсвийн санд оруулах, зэрэг ихэвчлэн эерэг нөлөөлөл үзүүлэх боломжтой байна. Гэхдээ төслийг хэрэгжүүлэх явцад байгаль хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх зэргээр орон нутгийн иргэдтэй үл ойлголцол бий болж болзошгүй тул төслийн явцад орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах хэрэгтэй.

III. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Уурхайн олборлолтын болон баяжуулах үйл ажиллагаа явагдах үед газар орчны эвдрэл тодорхой хэмжээгээр гардаг. Уулын ажил явуулах талбайд тоног төхөөрөмж байрлуулах, суурилуулах байгууламжуудын байршлыг зөв сонгох, үйлдвэр зохион байгуулалтын ажлыг зохих журмын дагуу хийснээр тухайн газар орчныг эвдрэлээс тодорхой хэмжээгээр хамгаалах болно.

Тухайн жилд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг тодорхой түвшинд хийнэ. 2026 оны үйлдвэрлэл болон олборлолтын явцад доорхи арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үйл ажиллагааг газар эдэлбэрийн хуулийн дагуу аймаг, сум, багийн засаг даргын захирамжаар зөвшөөрөгдсөн талбайд зөвхөн зураг төсөлд тусгагдсан хил хязгаарын дотор явуулна.
- Уурхайн гадаад болон дотоод тээвэрлэлтэнд зориулагдсан замыг зөвхөн нэг

маршрутаар хийх.

- Уурхайд ажиллах машин, техникүүдийг шатахуунаар цэнэглэх, урсгал засварыг хийхдээ зөвхөн тусгайлан зассан талбайд хийх.
- Ургамлын хар шороон хөрсийг тогтоогдсон хэмжээний зузаантайгаар эвдрэлд орох талбайгаас хуулан авч, тусгай овоолгод байрлуулах.

3.1 Газар ашиглалт хөрсний элэгдэл, эвдрэлийг багасгах

Төслийн хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийн үнэлгээнээс үзэхэд дээрхи сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Энэхүү арга хэмжээг төлөвлөхдөө “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль”-ийн дагуу хөрс хамгаалах нийтлэг арга хэмжээг үндэслэн боловсруулав.

- Бутлагдсан овоолгыг салхины зонхилох чиглэлийн дор байрлуулж ус, салхины нөлөөгөөр хүдрийн овоолгоос нарийн ширхэгтэй элс, чулуулаг зөөгдөж хөрсөн бүрхэвчид эвдрэл гэмтэл үүсгэхгүй байх.
- Хөрсний бохирдол, эвдрэлээс хамгаалахын тулд дараахи үйл ажиллагааг төлөвлөн гүйцэтгэнэ. Үүнд:
- Ашиглалтын явцад үүсэх овоолгуудыг төлөвлөлтийн дагуу тогтворжуулалт, хэлбэржүүлэлтийн ажлыг хийж, түүний гүйцэтгэлд хяналт тавих
- Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх
- Уурхайн технологийн дотоодын болон гадаад тээвэрлэлт, үйлчилгээний зориулалтын тээврийн хэрэгсэлийн зорчих сайжруулсан зам, талбайг иж бүрэн тэмдэгжүүлэн, тээврийн хэрэгсэл, уулын машин механизмын хөдөлгөөнийг заасан маршрутаар хязгаарлах,
- Суурины горитог дахь чөлөөт талбайг нутгийн болон ижил төст ургамлаар тарималжуулан, ногоон байгууламж байгуулах

3.2. Гадаргын болон гүнийн усны хамгаалал

- Дахин ашиглагдаж буй усыг зөвхөн үйлдвэрлэлд ашиглах төдий биш мөн уурхайн талбай дахь тоосжилтыг дарах, талбайг чийгшүүлэхэд ашиглах, уурхайн шүүрлийн усыг цэвэршүүлэн зам услах зэрэг ажил ашиглах, үерийн хамгаалалтын барилга байгууламжид усны угаагдал, гулдрилын эвдрэл зэргээс хамгаалах арга хэмжээг тусгах шаардлагатай.
- Үйлдвэр үйлчилгээний газарт хамаарах талбайд мод бут сөөг тарьж зүлэгжүүлэх нь үерийн их урсацын хэмжээг багасгах төдийгүй усаар зөөгдөх хатуу бодисын хэмжээг бууруулахад зайлшгүй хэрэгтэй.
- Хэрэглээнээс гадуурх ус ашиглалт болон хаягдал усыг чанарын шаардлагад нийцүүлэх.

- Бохир ус агуулах нүхийг гүний ус хөрсийг бохирдуулахгүй байх үүднээс газрын хөрсөнд нэвчхээргүй материалаар доторлон байнгын хяналт тавих
- Ундны усны эх үүсвэрт тогтмол хими-бактерологийн шинжилгээ хийлгэж шаардлага хангаж байгаа эсэхийг тогтмол хянана.
- Үйлдвэрлэлийн болон ахуйн хаягдал усаар гадаргын болон газрын доорхи усны нөөцийг бохирдуулахгүй байх арга хэмжээг авч ажиллах
- Шингэн хаягдал хөрс болон гүний усыг бохирдуулж байгаа эсэхийг шалгаж биологийн болон химийн шинжилгээ хийлгэнэ.

3.3. Ургамал амьтны аймгийг хамгаалах

- Техникийн нөхөн сэргээлт хийсэн ашиглагдсан талбайд богино хугацаанд биологийн нөхөн сэргээлт хийх.
- Хүн болон машин техникийг хөдөлгөөнийг тогтсон маршрутын дагуу явуулах.
- Хэт хуурайшилттай, салхи ихтэй нөхцөлд газрыг чийглэж услаж байх.
- Тоосны ялгаралтыг зөвшөөрөгдөх хэмжээнд байлгахын тулд байнгын хяналттай ажиллах.
- Байгаль орчны үнэлгээний ба нөхөн сэргээлт явуулж буй байгууллага, хүрээлэнтэй хамтран ажиллаж тоосжилт хэмждэг багаж төхөөрөмжтэй болж, тоосжилтонд хяналт тавих.
- Талбай дахь ховор ургамал, бэлчээр тэжээлийн үнэт ургамлуудыг хамгаалах
- Төслийн ажилчид нь ан, амьтан буй газарт анхааралтай хандан үйл ажиллагаагаа явуулах ба тэдгээрийн амьдарлын нөнхцөлийг алдагдуулахгүй байх.
- Тээврийн хэрэгслийн хурданд хязгаарлалт хийх.
- Ажлын талбайн гадна шөнийн цагаар хурц, тод гэрэл ба дуу, шуугиан гаргахгүй байх
- Төслийн үйл ажиллагаанаас бий болсон ухаш, нүх суваг шуудууг тойруулан хашаа барьж тэмдэгжүүлж мал амьтан ороож гэмтэж бэртэхээс хамгаалах.
- Хог хаягдлын менежмент боловруулан, түүнийхээ дагуу ажиллах.
- Ганц төслийн талбай гэлтгүй төслийн талбайн ойр орчимд хогийн цэг, бие засах газрыг байрлуулах.
- Уурхайн үйл ажиллагаа явуулж буй газрын ойролцоо ан амьтан агнахгүй байх, хамгаалах мэдээлэл, сурталчилгаа хийх, анхааруулсан зурагт хуудас байрлуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх.

IV. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дээр дурдсан болзошгүй гол сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг нөлөөлөлд өртөж болзошгүй бүрэлдэхүүн тус бүрээр нь ангилан тодорхойлов.

4.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Хүснэгт - 7. Агаарын чанарын нөлөөлөл

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт	Зардал төг
1	Хүнд машин механизмын утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах, үзлэг шалгалтыг хийх засвар үйлчилгээг тогтмол хийх	Механик инженер	250 мот/цаг тутамд тээврийн хэрэгслүүдийг тос, маслыг солиж байна.	
2	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх	Уурхайн дарга	7 хоногт 2-3 удаа, хур тунадас ихтэй үед усалгаа хийгдэхгүй	3,000,000
3	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн дагуу уурхайд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийнхээ төлбөрийг төлнө.	Уурхайн дарга	Үйлдвэрлэлийн ажилд хамрагдах тээврийн хэрэгсэлүүд	500 000
4	Уурхайн машин механизмуудын янданд шүүлтүүр тавих			
	Нийт			3,500,000

4.2 Газар, хөрсний элэгдэл, эвдрэлд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арга хэмжээ

Хүснэгт - 8. Хөрсний эвдрэлийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгыг төлөвлөгөөний дагуу цэгцтэй хураах	Уурхайн дарга	Үйл ажиллагааны зардалд орно.
2	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах хадгалалтанд хяналт тавих	ХАБЭА-н ажилтан	Хяналт тавьсан тэмдэглэл хөтлөх
3	Машин механизмын засвар үйлчилгээ хийх талбайд бетон хучилт хийх	Уурхайн дарга	Фото зураг баримтжуулалт байна. 5 000 000
4	Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	ХАБЭА-н ажилтан	Сургалтын агуулга, хөтөлбөрийг уурхайн даргаар батлуулах, сургалт семинар явуулах. 500 000
	Нийт зардал		5 500 000 төг

4.3 Усан орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтанд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Хүснэгт - 9. Усан орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Ус ашиглалтын гэрээ байгуулах, ус ашигласны төлбөр төлөх	ХАБЭА-н ажилтан	Үйл ажиллагааны зардалд орно. Төлбөр төлсөн баримт байна
2	Ахуйн бохир усыг цэвэршүүлэн ногоон байгууламжийн усалгаанд ашиглах	Уурхайн дарга	Фото зураг баримтжуулалт байна. 2 000 000

3	Усны хомсдол болон ус зарцуулалтын талаар ажилчидад сургалт явуулах, усны хэрэглээг ариг гамтай ашиглах талаар сургалт семинар явуулах	ХАБЭА-н ажилтан	Сургалтын агуулга, хөтөлбөрийг уурхайн даргаар батлуулсан байна. Фото зураг баримтжуулалт. 500 000
	Нийт зардал		2 500 000

4.4 Дуу чимээний үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах арга хэмжээ

Хүснэгт - 10. Дуу чимээний үзүүлэх нөлөөлөлийг бууруулах арга хэмжээ.

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Олборлолтын ажлыг өдрийн цагаар гүйцэтгэх	Уурхайн дарга	Цагийн хуваариар зохицуулах
2	Дуу шуугианы хэмжилт (2 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийж, дуу, шуугиан бүхий машин механизмийн ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгах	Уурхайн дарга, ХАБЭА-н ажилтан	Хяналт шинжилгээний хөтөлбөрт төлбөр орно.

V. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Өндөр овоо” хайлуур жоншны орд төсөл нь 2021 онд үйл ажиллагаагаа эхлүүлэн, ашиглалт 1 жил явагдах ба нөхөн сэргээлтийн ажил 2024 онд хийгдэж эхлэх төлөвлөгөөтэй байна. Төсөл хэрэгжүүлэгч “ХТД” ХХК нь ашигт малтмал эрэл хайгуулын шатнаас эхлэн орон нутгийн удирдлагуудтай уулзаж сургуулийн тохижилт, хашаа хайс будах, өвөлжилтийн бэлтгэл ажил зэрэг Бор-өндөр сумын иргэдтэй хамтран ажиллаж ирсэн билээ. Өндөр овоо ордыг ил болон далд уурхайн аргаар ашиглах бөгөөд эвдрэлд өртөх талбай бага учир нөхөн сэргээлтийн ажлын сум орон нутгаас санал авсан дагуу дүйцүүлэн хамгаалах арга хэмжээгээр шийднэ.

Нөхөн сэргээлтийн ажлын техникийн үе шатанд орд газрыг ашиглаж дууссаны дараа болон ашиглалтын явцад уурхайн чөлөөлөгдсөн орон зайг цаашид аж ахуйн үйл

ажиллагаанд үргэлжлүүлэн ашиглах зорилгоор нөхөн сэргээхэд техникийн нөхөн сэргээлтийн гол зорилт юм.

Хүснэгт - 11. Нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөгөө.

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Мод, сөөг бутлаг ургамал тарих боломжтой газар мод тарих.	Уурхайн дарга	Модны суулгац худалдан авах, 3 000 000 500ш 9-р сард
	Нийт		3 000 000

VI. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсэнийн үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн зорилго болно. Дүйцүүлэн хамгаалах газрыг тогтоохдоо нөлөөлөлд өртсөн газартай ойр байх, экологийн хувьд дүйцэхүйц байх, дүйцүүлэн хамгаалах хугацааг нөлөөлөл үргэлжлэх хугацаатай харьцуулж тогтоох, урт хугацааны хамгааллыг хангах, зарчимуудыг баримтлах шаардлагатай. Үүнээс гадна дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ нь шинээр хамгаалалт бий болгосон, эсвэл биологийн олон янз байдлын хэвийн нөхцөлд илүү эерэг нөлөөлөл үзүүлсэн байх шалгуур тавигдана.

Манай уурхайн хувьд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд орон нутгийн удирдлага, байгаль орчны мэргэжилтэн болон улсын байцаагч нартай харилцан тохирон төсөл хэрэгжиж буй талбайтай ойр орших талбайд 2000 мод тариалахаар төлөвлөж байна.

Хүснэгт - 12. Дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөө.

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Бор-Өндөр суманд	Уурхайн дарга	Орон нутагт хүлээлгэж өгсөн акт. Ажил гүйцэтгэх үеийн фото зураг
	Нийт		7 000 000

VII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нүүлгэн шилжүүлэх, нутгийн иргэдийн эрүүл мэнд, эрх ашиг, амьжиргаа, соёлын өвийг хамгаалах болон бусад төлөвлөлттэй хэрхэн уялдсан байдал зэрэг нь нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний шалгуур үзүүлэлт болох бөгөөд, төсөл хэрэгжих явцад, төслийн талбайтай ойр орших малчид, нутгийн иргэдийн санал гомдол ирсэн тохиолдолд, санал гомдлыг хүлээн авч харилцан тохиролцон шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх бөгөөд тодорхой хэмжээний зардал мөнгөтэй холбоотой асуудлыг шийдвэрлэнэ.

Хүснэгт - 13. Нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөө

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Төслийн талбайтай ойр орших нутгийн иргэд малчидаас ирсэн гомдол, саналыг хүлээн авч шийдвэрлэнэ.	Уурхайн дарга	Уурхайн удирдлагад хандсан албан хүсэлт, саналт гомдол байна, баримтжуулна.
	Нийт		1 000 000

VIII. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн хувьд гүний чиглэлтэй бөгөөд далд уурхайн малталтын явцад түүх соёлын дурсгалт зүйл болон түүхийн ховор олдвор олдсон тохиолдолд нэн яаралтай олборлолтын ажлыг зогсоож холбогдох албан тушаалтан болон газарт мэдэгдэж шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт - 14. Түүх соёлын өвийг хамгаалах ажлын төлөвлөгөө.

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Олборлолтын явцад гарч ирсэн олдвор, түүхийн дурсгалт зүйл гарч ирсэн тохиолдолд шаардлагатай ажлыг авч хэрэгжүүлнэ.	Гүний уурхайн ээлжийн мастер, маркшейдер	Ээлжийн мастерын мэдэгдэл байна, түүхийн дурсгалт олдвор олдсон тохиолдолд фото зураг баримтжуулалт болон холбогдох газрын дүгнэлт байна.
	Нийт		Ашиглалтын зардалд орно.

IX. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Осол эрсдэлгүй үйл ажиллагаа хэвийн явуулахын тулд ажилчидыг эмчийн үзлэгт тогтмол хамруулж осол эрсдэлийн сургалт зохион байгуулж ажиллах

Д.д	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	ХАБЭА	Сургалтын хөтөлбөр хавсаргах 500 000
2	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх	ХАБЭА	Төлөвлөгөө хийж батлуулах 1 000 000
3	Химийн бодисыг ашиглах, хадгалах, тээвэрлэх үед гарах осол эрсдлийг тооцож мэргэжлийн байгууллагаар осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж чанд мөрдөн ажиллах, ажилчдыг гарын авлага болон хамгаалах хувцас хэрэгслээр хангах, химийн бодисын хаяг шошго, хадгалах сав болон санамж зөвлөгөөг байршуулах, химийн бодисын хаягдлын арга хэмжээ авах, г.м	ХАБЭА	Ашиглалтын зардалд орно.
	Нийт		1 500 000

X. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежментээр хэрэгжүүлэх боломжтой ажлууд:

- Уурхайн хотхоны гэрүүдийг утаагүй түлшээр галлаж байх
- Хуванцар сав, төмөр лааз, ялгаж цуглуулаад тушааж байх. Жилд дунджаар 1000 ширхэг хуванцар сав гарч байгаа ба байгальд хаягдах сөрөг нөлөөлөл нь нэг ширхэг хуванцар сав байгальд шингэлгүй 200- 500 жил болно гээд бодоод үзэхэд байгальд учруулж байгаа нөлөө нь маш их юм.
- Шил нь байгальд хэзээ ч устахгүй материал учраас варены шилийг аль болох хаяхгүй байх хэрэгтэй. Варены шилийг ногоо даршилж хийн дахин ашиглаж болно.
- Харин хаягдал ногооны хальс болон хоолны үлдэгдлийг ашиглан хөрсийг ялзмагжуулахад ашиглаж болно.

- Үйлдвэрт тос арчих зориулалтаар хуучин хувцас авч ашиглах нь эдийн засгийн болоод экологийн хувьд үр дүнтэй арга юм.
- Бүх ажилтан албан тушаалтнууд нь ахуйн хог хаягдлаа дахин ашиглагдах боломжтой хогнуудыг ялган хаяж занших хэрэгтэй.

Хүснэгт -15. Хог хаягдлын менежментээр хэрэгжүүлэх ажил

Д.д	Хог хаягдлын талаар хийгдэх ажлууд	Хариуцах эзэн	Шалгуур үзүүлэлт
1	Ахуйн хог хаягдлаа эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлнэ.		Гэрээ байна. Зардал нь үйл ажиллагааны зардалд орно. Ажил эхлэхэд
2	Хог хаягдлын төлбөрөө төлнө.		Төлбөр төлсөн баримт байна. Зардал нь үйл ажиллагааны зардалд орно.
3	Хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, зайлуулах, дахин ашиглах тогтолцоог нэвтрүүлэх		Хогийг ангилж хаях. 1 000 000
4	Зуны улиралд хогийн сав болон ажилчдын амьдрах байр. гал тогоонд хортон шавьжийн ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх		Улаанбаатар хотын гоц халдвартын төвөөр хийлгэх. Зардал нь 500 000 төгрөг
5	Ахуйн бохир ариутгах. халдваргүйжүүлэх. задлах бодис худалдаж авах зардал		5 болон 10 сард 2 удаа 500 000 төгрөг
	Нийт		2 000 000

ХІ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга болон хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны мэргэжилтэнгүүд хариуцан ажиллана. Доорх ажлуудыг компанийн захирал тушаал гаргаж баталгаажуулна.

Хүснэгт -16. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал. төг	Хариуцагч
1.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаарх сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран жилд 1 удаа зохион байгуулах	5, 10 сард	1000000төг	Уурхайн дарга
2	Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгаалалын хувцас хамгаалах хэрэгсэлээр бүрэн хангах	Ажил эхлэх үед	Үйл ажиллагааны зардалд орсон	Уурхайн дарга

ХИ. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, талуудад тайлагнах хуваарь

Хугацаа	Олон нийтэд тайлагнах, танилцуулах ажлын жагсаалт	Зохион байгуулах хүний албан тушаал
2026 оны 9-р сард	холбогдох мэргэжилтэнгүүдийг газар дээр нь танилцуулна.	Байгаль орчны ажилтан, Уурхайн дарга болон компанийн захирал Зардал нь үйл ажиллагааны зардалд орно.
2026 оны 11 сарын 1-нд багтаан	Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангаа боловсруулж байгаль орчны албанд хүргүүлнэ.	

ХIII. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ	Хяналт шинжилгээний үзүүлэлт	Хяналт шинжилгээний хэлбэр. зардал	Хяналт шинжилгээ	Хяналт шинжилгээ явуулах	Хяналт шинжилгээ хийх багаж. холбогдох стандарт
1	Агаар	Тоосжилт (PM10, PSM, PM25); - Гадаад болон дотоод орчны дуу чимээ, доргио, чичиргээ; - Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин); - Бохирдлын цэгэн эх үүсвэр (O ₂ , SO ₂ , NO ₂ , CO)	Агаарын шинжилгээний 2 цэгт жилд 2 удаа хэмжилт хийлгэнэ. Нэг удаагийн шинжилгээний хөлс 100 000 төг. 2 цэг*1 удаа*100 000= 200 000 төг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2011 оны 10 сарын 10-ны өдрийн А-342 дугаар тушаалын хавсралтаар тооцов.	7 сард	Уурхай, уурхайн зам	Агаарын тухай хууль. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль. Агаарын чанар- хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 6063: 2010. Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2007
2	Ус	Физик хими, нянгийн бүрэн шинжилгээ, Хүнд металын шинжилгээ, БХХ болон цэвэршүүлсэн бохир усны стандартад заасан үзүүлэлтүүд Химийн бодисын хаягдлын далангаас усны дээж авах	худгийн ус жилд 2 удаа дээжлэлт авч шинжилгээнд шинжлүүлнэ. үнэ 161700 төг 2цэг*1 удаа*161700 төг =323400 төг	10сард	Худаг, уснаас хаягдлын далан	Усны тухай хууль. Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2008. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010. Ундны усны. эрүүл ахуйн

			*УСУГ итгэмжлэгдсэн лабораторийн үнэ			шаардлага. чанар. аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:
3	Хөрс	Ялзмаг, урвалын орчин (pH), давсжилт, карбонат (CaCO ₃), хөдөлгөөнт кали (K ₂ O), хөдөлгөөнт фосфор (P ₂ O ₅), Шингээгдсэн сууриуд Ca, Mg Механик бүрэлдэхүүн, чулуу, чийг, амь чийг, эзлэхүүн жин Хар тунгалаг (Pb), кадми (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), Мөнгөн ус (Hg), цианид натри, хүнцэл (As)	Хөрсний хяналт шинжилгээний 2 цэгт жилд 2 удаа Хөрсний механик бүрэлдэхүүн. ялзмаг 20000төг1 Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 45.0 мян.төг 2 2 цэг* 1 удаа* 65000төг = 130 000төг Газарзүйн хүрээлэнгийн хөрсний төв лаборатори 2-Эс жи Эс лаб ХХК үнэ авав.	10 сард	Уурхайн шимт хөрсний овоолго ахуйн бохир усны хаягдал орчимд	– MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр. төрөл – MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох – MNS2305-94 Дээж авах. савлах. тээвэрлэх. хадгалах журам – MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх
4	Нийт		1 000 000 төг томилолтын зардал багтсан.			–

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв

Д.д	Зардлын утга	Нийт зардал,сая.төг
1	Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	3 500 000
2	Газар болон хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	5 500 000
3	Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын зардал	2 500 000
4	Дуу чимээний үзүүлэх нөлөөлөлийг бууруулах арга хэмжээ зардал	0
5	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	3 000 000
6	Дүйцүүлэн хамгаалах ажлын зардал	7 000 000
7	Нүүлгэн шилжүүлэх ажлын зардал	1 000 000
8	Осол эрсдэлийн менежментийн зардал	1 500 000
9	Хог хаягдлын менежментийн зардал	2 000 000
10	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	1 000 000
11	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	1 000 000
	2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	28 000 000

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **28 000 000** төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө болгож 14 000 000 төгрөгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9,15 дахь заалтанд зааснаар Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулна.